

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**УУЛ УУРХАЙН ЗАРИМ ТӨСЛҮҮДИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН
ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ТУХАЙ**

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Гадаад валютын улсын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” 47 дугаар тогтоолын хавсралтаар баталсан улсын тусгай хамгаалалттай газрын хилийн заагаас энэ тогтоолын хавсралтад заасан солбицол бүхий талбайг хассугай.

2.Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших стратегийн ач холбогдол бүхий Гацууртын ордыг Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолд нийцүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбогдох асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай.

Гарын үсэг

ХАСАХ ТАЛБАЙН ХИЛИЙН ЗААГ

Байршил: Сэлэнгэ аймгийн Мандал, Төв аймгийн Борнуур сум

Талбайн хэмжээ: 6207.28 га

№	Аймгийн нэр	Ц/Д	Уртраг			Өргөрөг			Талбайн хэмжээ /га/
			град	мин	сек	град	мин	сек	
1	Сэлэнгэ, Төв	1	106	27	31.20	48	37	17.39	6207.28
2		2	106	27	31.20	48	39	1.85	
3		3	106	31	16.27	48	39	1.85	
4		4	106	31	16.27	48	38	31.86	
5		5	106	33	16.20	48	38	31.86	
6		6	106	33	16.26	48	39	1.89	
7		7	106	33	16.26	48	39	18.87	
8		8	106	33	35.26	48	39	18.87	
9		9	106	33	35.26	48	39	31.86	
10		10	106	34	55.26	48	39	31.86	
11		11	106	34	56.25	48	38	51.87	
12		12	106	40	21.26	48	38	51.87	
13		13	106	40	21.26	48	37	31.86	
14		14	106	40	56.20	48	37	1.80	
15		15	106	40	13.20	48	36	36.80	
16		16	106	39	13.20	48	37	9.80	
17		17	106	38	1.20	48	37	3.80	
18		18	106	38	1.20	48	37	31.80	
17		19	106	35	51.25	48	37	31.86	
18		20	106	35	51.25	48	36	51.86	
17		21	106	34	56.25	48	36	51.86	
18		22	106	34	56.25	48	36	31.86	
17		23	106	32	37.25	48	36	31.86	
18		24	106	31	46.26	48	36	11.85	
17		25	106	31	29.80	48	36	5.12	
18		26	106	28	0.95	48	37	8.24	